



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/93

Батноров сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн журам)-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “ Сумын сүсэгтэн олны байрны их засварын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заагдсан хугацаанд тус ажлыг бүрэн гүйцэд хийлгэн хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Чимэгсүрэн(Нийгмийн бодлогын
мэргэжилтэн)

Гишүүд: Г.Цолмонтаяа (Соёл сангийн нягтлан
бодогч)

А.Эрдэнэтуяа (Хууль, Эрх зүй хариуцсан
мэргэжилтэн)

Н.Энхтайван (Олон нийтийн байцаагч)

Г.Одбаяр (Иргэн)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, явцын чанар, ажлын тоо хэмжээ, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд захиалагч байгууллагыг бүрэн төлөөлж хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмолжуулан удирдлагыг мэдээллээр хангаж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, явцын дүгнэлт, гүйцэтгэлд акт үйлдэн тус ажлыг бүрэн хүлээж авах ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР